

## 12 дугаар ангийн монгол хэлний хичээлийн ажлын дэвтэр

1

### Өгүүлбэрийг гишүүд, гишүүн өгүүлбэр, хэлц, "гэ", "хэмээ" холбох үг бүхий өгүүлбэрээр дэлгэрүүлэх

Сурагчийн овог нэр: .....

Эхэлсэн .... он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**Дасгал 1.** Өгүүлбэрийг гишүүд, гишүүн өгүүлбэр, хэлц, "гэ", "хэмээ" холбох үг бүхий өгүүлбэрээр дэлгэрүүлэх



**Гэ - т өгүүлбэр:** Нэг хам бүтцийн дотор 2-3 өгүүлэгчийн өгүүлбэрийг яльгүй өөрчлөн, эсвэл өөрчлөлгүй оруулж байрлуулан холбодог зүй тогтол бүхий өгүүлбэрүүд нь гэ - , хэмээ – холбох үгээр холбогдсон байдаг. Тухайлбал: *“Нас чинь эрийн цээнд хүрсэн төдийгүй, алдар нэр чинь олонд тодорсон биш үү!” гэж Жамьян гүний хэлэхэд Сүх “Жа” гээд янжуурыг авч асаав (Д.Нам)* гэхэд энд гурван өөр хүний хэлэхүйн өгүүлбэр байна.

**Алхам 1.** Гэ – язгуур бүхий холбоосоор холбогдсон хоёр өгүүлбэрийг зааглан ялгаж бичнэ үү. Үлгэрлэвэл: Ёс суртахууны үнэлэмж нь хүний амьдралын хэм хэмжээ болдог учраас хүн энэ ертөнцөд үнэн шударгаар амьдарч, гагцхүү үнэнийг өгүүлж, үнэний зам мөрөөр тууштай явах ёстой гэсэн итгэл үнэмшлээр төлөвшдөг.

**Эхний өгүүлбэр нь:** Ёс суртахууны үнэлэмж нь хүний амьдралын хэм хэмжээ болдог учраас хүн энэ ертөнцөд үнэн шударгаар амьдарч, гагцхүү үнэнийг өгүүлж, үнэний зам мөрөөр тууштай явах ёстой.

**Холбоос нь:** гэсэн

**Дараагийн өгүүлбэр нь:** Итгэл үнэмшлээр төлөвшдөг гэх мэт.

Өгүүлбэр нь:	Эхний өгүүлбэр нь	Холбоос нь	Дараагийн өгүүлбэр нь
1.Шударга үнэн, үнэн шударга гэдэг хоршоо үгээс үнэн гэдэг нь ёс суртахуунтай холбоотой болохыг мэдэж болж байна.			
2.Үнэнийг дагах, баримтлах нь хүний сэтгэл санаа амар амгалан байх, урт удаан, үүрд хүндтэй амьдрахын үндэс болдог гэсэн санаа зүйр цэцэн үгсэд нэлээд хэмжээгээр илэрдэг.			
3.Ертөнцийн жам ёс хийгээд бодит байдалтай нийцсэн, хүний амьдралд эерэг сайн гэж тооцдог сайн үйл, шударга ёс, зөв үйлдэл бүхэн амьдралын үнэт зүйл, үнэ цэнтэй зүйл болно.			
4.Аливаа нийгэм хийгээд нийт төрөлхтөнд үнэ цэнтэй сайн			

сайхан гэж хүлээн зөвшөөрдөг бүхэн үнэнийн учир холбогдлыг агуулна.			
5. “Үнэн гэдэг хамаг сайны үндэс” хэмээх зүйр үгийн утга энгийн ойлгомжтой боловч цаанаа үнэнийн мөн чанар, ач холбогдлыг ургамлын шинжтэй адилтган зүйрлэсэн нь бодит ертөнцтэй харьцсан танин мэдэхүйн туршлагаас үүдэлтэй. (А.Цог - Очир)			

**Алхам 2.** Өгүүлбэрүүд нь дурдсан 3 хэв маягийн алинд хамаарах вэ?

Хөндлөнгийн этгээдийн хэлсэн оруулбар өгүүлбэрийг гол өгүүлбэрт багтааж оруулах хэв маягууд:


1. Гол өгүүлбэрийг эхэнд өгүүлж, оруулбар өгүүлбэрийг “гэж” холбоосгүйгээр эцэст хэлэх.
2. Тусах үйл үгийг хурааж, “гэ-” холбох үгээр холбон найруулах.
3. Хөндлөнгийн үгийг “гэ-”, “хэмээ-” холбох үгээр холбох.

Д/д	Өгүүлбэрүүд	Аль хэв маягт хамаарах вэ? Өмнөх дугаарыг тавиарай.
1	Маргааш цагаан сарын шинийн нэгэн гэгчийг мэдэж байна уу, үгүй байна уу мал чи» гээд туужуугаар нуруун дунд нэг цохиж аваад, уурлан зогсоход Цэрмаа эсэргүүцэх аргагүй... (Д.Н)	3 г.м
2	Хогийг гадна асгаад ирвэл, Мядагмаа бас дуудаж: “Нүүрний ус асга” гэнэ. (Д.Н)	
3	Чүлтэм хүрч хэлж: “Одоо чи миний хамт явж аж төр” (Д.Н)	
4	Болд “Хулгайч юм уу, дээрэмчин юм уу, эсвэл гөрөөчин юм уу?” гэж гайхан юу ч болов мордъё гэж тушаатай морь руугаа явж хүрэхийн зуур өнөөх гурван хүн шогшин ирж хөндөлдөөд (Д.Н)	
5	Болд сочин цааш нарийвчлан асуувал, дөч гаруй настай нэг хар хүн энэ болбол, Очирбатын яам гэгч юм гэнэ. (Д.Н)	
6	Балдан өгүүлэх нь: Уйлж сандраад ямар тус ажээ. Харин хотоос ардын цэрэг ирж байгаа тул эртхэн түүнд хэл болон газарчилбал, гагцхүү аврагдах магадгүй. (Д.Н)	
7	Тэр усан дээр очъё гэж би хашхиран хэлэв. (Ц.Д)	
8	Түүний ярьсан нь: Манай нутагт Гомбо гэж залуу гэргүй байсан юм. (Ц.Д)	
9	“Одоо чи нэг сайн морьтой болжээ. Энэ морио л хайрлаж эдэл” гэгцгээв. (Ц.Д)	
10	Гомбын гавал түүнийг хөөж ойртоод байдаг юм гэж хүн ярьдаг юм. (Ц.Д)	


**Алхам 3.** Нэг өгүүлбэрийг нөгөө өгүүлбэрт “гэ-”, “хэмээ-” холбох үгээр холбон оруулах.

Нэг өгүүлбэрийг нөгөө өгүүлбэрт “гэ-”, “хэмээ-” холбох үгээр холбон оруулахад хувиргах, эс хувиргах хоёр янз байдаг.

Үлгэрлэвэл:



**Алхам 1.** Хувиргах, эс хувиргах хоёр янзад тохируулж 5 өгүүлбэр зохион бичээрэй.



Сурагчийн овог нэр: .....

Эхэлсэн ... он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

## Дасгал 2. “Гэ-”, “хэмээ-” холбох үгсийн утгыг ойлгож, хувиргах

**Алхам 1.** Тайлбарыг уншаарай. Дор өгсөн өгүүлбэрүүдэд “гэ-”, “хэмээ-” үйл үг нь тусах үйл үгийн утгаар орсон эсэхийг ажигла. Хүснэгтэд уул өгүүлбэрийн өмнөх дугаарыг тавиарай.



Холбох “гэ-”, “хэмээ-” үгийн өмнө орсон төгс өгүүлбэр нь утгаараа шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр болно. Учир нь энэхүү “гэ-”, “хэмээ-” үйл үг нь тусах үйл үг болно. Жишээ нь:

- а). “Дорлиг [түүнийг хуучин бууны хугархай] гэж хэлэв” гэхэд холбох “гэ-”-ийн өмнөх оруулбар өгүүлбэр нь тусагдахуун гишүүн өгүүлбэр болно.
- б). “Тэнгэр над үрийн хутаг эс заяасан тул намайг хадан гэрт гарахад энэ муу нохой, юуны өмнө, миний хошуу засгийн хэргэм залгамжлах гэж гүйх юм байна шүү” (Б.Р.) гэхэд холбох “гэ-” нь өмнөх “залгамжлах” гэдэг үгтэй нийлж, зорих утга илтгэж буй тул бие даасан тусах утгаа гээсэн байна.

1. **Гэвч** хэдхэн жил цэргийн алба хаагаад буцаж ирнэ.
2. Чи гэрээ цагаан болгоод, малаа олон болгож сайн сууж байгаарай **гээд** толгойг нь илэхэд...
3. Чи намайг мартаггүй бол би чамайг мартаггүй **гэж** хэлэв.
4. “Би мэнд байна, чи мэнд байна уу? Одоо бичих онц сонин зүйлгүй” **гэсэн** нэг ижил утгатай байснаас гадна...
5. “Газрын хол, усны уртаас цагаан цаасаар бие болгож, хар үсгээр хэл болгож, хайрт чинийхээ мэндийг лавлая” **гэх** мэтийн хэдэн чимэгтэй үг захидал бүрд байдаг байв.
6. **Гэтэл** Цэндийг хоёр сар аян хийгээд эргэж ирэхэд Лхам ондоо нөхөртэй болоод сууж байв.
7. Хааяа бодовч Солийг ер нь өөртөө тохирохгүй эхнэр юм **гэж** санадаг боллоо.
8. Эхнэрээ солих **гэдэг** муухай хэрэг.
9. Түүний эхээс таван хүүхэн төрөөд зургаадугаар хүүхнийг төрөхөд эх нь дахин эрэгтэй хүүхдийг хүсэж түүнд Соль гэж нэр өгсөн юм **гэнэ** билээ.
10. Энэ мөн сайхан хүүхэн байна **гэж** нэг цэрэг хэлсэнд бусад нь цөм зөвшөөрөв.

“гэ-”, “хэмээ-” холбох үгс нь тусах үйл үгийн утгаар орсон өгүүлбэр	“гэ-”, “хэмээ-” холбох үгс нь бие даасан тусах утгаа гээсэн өгүүлбэр

**Алхам 2.** Хөндлөнгийн этгээдийн хэлсэн оруулбар өгүүлбэрийг гол өгүүлбэрт багтааж оруулах 3 хэв маягийг сэргээн санаад (Сурах бичгийн 21 дүгээр талд буй.) даалгаврыг гүйцэтгээрэй.

Д/д	Өгүүлбэрүүд	Оруулбар өгүүлбэрийг гол өгүүлбэрт	Өгүүлбэрийг өөр хэв	Оруулбар өгүүлбэрийг гол өгүүлбэрт

		багтааж оруулах хэв маягийн аль нь вэ?	маягаар хувиргана уу.	багтааж оруулах хэв маягийн алианаар хувиргасан бэ?
1	- Аавдаа очиж золго гэж хүүгээ Бат руу түлхэв.	Үлгэр нь: Хэлэх, өгүүлэх тусах үйл үгийг хурааж гэ – холбох үгээр холбон найруулсан хэв маяг.	Хүүгээ Бат руу түлхээд “Аавдаа очиж золго” гэж хэлэв.	Хөндлөнгийн үгийг гэ – холбох үгээр холбосон хэв маягаар хувиргасан.
2	Цэцэн хүн цэргийн алба хааж сургууль эрдэм сурч, хорин нас хүрч нэлээн томоожсон хойно тохирсон эхнэрийг авч, тогтвортой айл болдог юм гэсэнд Бат тайлбарлаж хэлэв: “-Эхнэрүүдэд сайн муу гэж ялгаа байдаг юм”			
3	Соль бол хатсан борц шиг хүүхэн, энэ чинь түүхий сүүний бяслаг шиг булцайсан цагаан хүүхэн байна гэхэд цэргүүд: “-Энэ балархай зураг дээр цагаан хар нь төдий л тодорхойгүй байна” гэж инээлдэв.			
4	Нэг цэрэг хэлэв: “-Эхнэрээ хаяад бас муулдаг бол буруу хэрэг дээ”.			
5	Одоо Хишиг хүүхэнд хэдүүлээ хамтарч захидал бичвэл ямар вэ? гэхэд бүгдээрээ түүний саналыг зөвшөөрөв.			
6	Захидлын эхийг Бат зохиож бичсэн нь: “Эрхэм нөхөр сайн малчин Хишиг танд хилийн харуулын хэдэн цэрэг энэ захидлыг бичив”.			
7	Хэрэв та боломжтойд үзэж хариу захидал бичвэл бид бид ихэд баярлана” гэж бичээд			

	хойно нь цөм гарын үсгийг зурав.			
8	Гэрт манай ээж байна гэв.			
9	Сайн уу? гэж хэлээд хартал тэр хүүхэн Батын хуучин эхнэр Соль мөн бололтой харагдана.			
10	Дурласан Хишиг чинь би байна гэж дахин хэлбэл, Бат сая учрыг мэдэж...			

**Алхам 3.** Доорх өгүүлбэрүүдэд буй “гэ-”, “хэмээ-” язгуур бүхий холбох үгсийг тохирох холбоосоор солин найруулж бичээрэй.

д/д	Өгүүлбэрүүд нь	Холбоосыг солин найруулсан нь:
1	<b>Гэвч</b> шаргачин сүүлчийнхээ хүчийг дайчлан харайсаар байв. (Ч.Л)	Тэгэвч шаргачин сүүлчийнхээ хүчийг дайчлан харайсаар байв. (Ч.Л) г.м.
2	Сум байна уу? <b>гэж</b> хашхирах дуу машин дотроос хэд дахин сонсогдсоноо хэсэг чимээгүй болоод цонхоор арзайн гарсан буунуудаа татаж аваад хөл рүүгээ хаялцгаав. (Ч.Л)	
3	Хүүхдүүд нь тус бүр айл болоод өөр нутагт байдаг ба эх нь Ханд <b>гэгч</b> ная гаруй настай эмгэн хамт амьдардаг байв. (Ч.Л)	
4	Гэвч нээх арга нь даанч олдохгүй болохоор яая <b>гэх</b> билээ дээ. (Ч.Л)	
5	Би зохиолч хүн бас сонины газар ажилтай <b>гээд</b> л өөрийнхөө тухай товч ярьж өглөө. (Ч.Л)	
6	<b>Гэтэл</b> дуугардаггүй. (Ч.Л)	
7	Идэж ууж байтал эмээ над руу ширтэн хэсэг ажсанаа урт <b>гэгч</b> нь санаа алдаад “Эмээ нь хүүдээ нэг юм яривал чи олон хүнд хэлж өгч чадах уу?” (Ч.Л)	
8	Манайх үргэлж л Жамбал <b>гэдэг</b> айлтай хамт байдаг байлаа. (Ч.Л)	
9	“Ханд минь чамдаа би хязгааргүй дасжээ” <b>гэж</b> палхийтэл шууд хэлдэг байна шүү <b>гээд</b> эмгэн инээмсэглэх мэт болсноо, ер нь Юндэн бүрэг мэт боловч бодсоноо эв хавгүй цөл цал гэтэл цөмийг хэлдэг хүн байсан юм сан. (Ч.Л)	
10	Хонь хотолж байгаад Юндэн урьдахаа давтаж хэлэхэд нь би тэр яриаг займруулах <b>гэж</b> “Чи ганцаараа гучин тэмээгээр Хүрээ жин тээж чадах уу” <b>гэлээ</b> . (Ч.Л)	

Сурагчийн овог нэр: .....

Эхэлсэн .... он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**Дасгал 3. "гэ - ", "хэмээ - " үйл үгийн хэл зүйн утга, үүргийг тодорхойлж, түүгээр өгүүлбэр дэлгэрүүлэх. Эшлэл оруулсан өгүүлбэрийг тайлбарлах, найруулах**



Бусдын үг яриа ном бүтээлээс авсан эшлэлийг “гэ - , хэмээ-“ холбох үгээр холбон шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр бүтээдэг. Мөн өгүүлэгч этгээд нь найруулгад өөрийн санаа, дэвшүүлсэн асуудлаа үнэн магадтайг батлах баримт болох өгүүлбэрийг эдгээр холбох үгээр холбодог.

**Алхам 1.** Өгүүлбэрээс эшлэл авсан хэсэг, холбоос хэлбэржилтийг дараах байдлаар задлаарай. Үлгэрлэвэл:

“Нойроо бэхлэх үгүй хүн манаа битгий мана. Эвээ чадахгүй бол яарч битгий ханил.” хэмээн Д.Равжаагийн “Сэтгэлийг амраагч” сургаалд өгүүлжээ.

**Эшлэл авсан хэсэг:** Нойроо бэхлэхгүй бол манаа битгий мана. Эвээ чадахгүй бол яарч битгий ханил.

**Хаанаас эшилсэн:** Д.Равжаа “Сэтгэлийг амраагч” сургаал

**Холбоос хэлбэржилт:** хэмээн: хэмээ + н: хам холбох нөхцөлөөр хэлбэржсэн.

1. Эрдэмтэн С.Дулам “Монгол бэлгэдэл зүй” бүтээлдээ хүний аж амьдралд бие боловсрох насыг “сэвлэг буржийх хорин нас”, эрийн цээнд хүрэхийг “галзуу барын аманд гараа хийхээс буцахгүй нас” хэмээсэн нь бий.

**Эшлэл авсан хэсэг** .....

**Хаанаас эшилсэн** .....

**Холбоос хэлбэржилт** .....

2. Б. Явуухулан “Үүлэн хархүү салхин хүлгээ унаж

Үдшийн тэнгэрт морин туурай пижигнэнэ.

Алагхан нуга цэцгэн алчуур даллавч

Алчуур дүүрэн шүүдрэн нулимстай үлдэнэ.” гэж “Нуга дахь зуны өглөө” шүлэгтээ дүрсэлжээ.

**Эшлэл авсан хэсэг** .....

**Хаанаас эшилсэн** .....

**Холбоос хэлбэржилт** .....

3. Монгол “Хорин нэгтийн тайлбар толь” – д “Үг үнэнч явдал батыг үнэн хэмээмүй. Бас хэрэг худал ташаа үгүйг мөн үнэн хэмээмүй. Ташаа үгүйг үнэн хэмээмүй.” гэсэн тайлбар буй.

**Эшлэл авсан хэсэг** .....

**Хаанаас эшилсэн** .....

**Холбоос хэлбэржилт** .....

4. Эрдэмтэн Д.Цэнд “Тэр билиг авьяастай бас нарийн мэдрэмжтэй” өгүүлэлдээ “Д.Норов хөнгөн хуумгай хөдөлдөггүй их бодож сэтгэж, сэтгэл зүрхэндээ эхлэн бичиж, дараа нь цааснаа буулгадаг, уран зохиол бол зохиолчдоо хайрлаж, бүтээлийн жаргал авчирдгийг сэтгэл зүрх, яс махаараа мэдэрсэн зохиолч.” хэмээжээ.

Эшлэл авсан хэсэг .....

Хаанаас эшилсэн .....

Холбоос хэлбэржилт .....

5. “Нэг яриаг сонсож болох, нөгөө нэгийг сонсох хэрэггүй, бас нэгийг сонсохгүй байж болохгүй.” гэдгийг эрдэмтэн Ц.Сүхбаатар “Монгол хэлний найруулга зүй” УБ., 2012 номдоо дурджээ.

Эшлэл авсан хэсэг .....

Хаанаас эшилсэн .....

Холбоос хэлбэржилт .....

**Алхам 2.** Эх сурвалж ба эшлэлийг “гэ -, хэмээ” холбоосоор холбон найруулж, өгүүлбэр бүтээгээрэй.





Сурагчийн овог нэр: .....

Эхэлсэн .... он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

#### Дасгал 4. Дүрслэг өгүүлбэрийн санааг ойлгож, уг үйл явдалтай адилтган, холбож дэлгэрүүлэх.



Ерийн өгүүлбэрийн санааг хэлц нэгжийн далд утгаар дэлгэрүүлж, үйл явдалтай адилтгах замаар хэлэх санааг улам лавтган тодруулахад “гэгчээр, гэгчийн үлгэрээр, гэж” гэсэн үгээр холбодог.

#### Алхам 1. Хэлцийн санааг ухаарч, тохируулаарай.

##### 1.1. Хэлцийн утгыг тунгаан цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.

- |                                                                                                                                                   |                                        |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------|
| a. Тэднүүс Батбаярыг дагаж ..... гэгчийн үлгэрээр болох гэвэл дураараа болог. (Б.Р)                                                               | 1. илжиг модон хударгандаа             |
| b. .... гэгчээр хүрээ эргэхээр гарсан Чимэг, Цэцэг хоёр хүрдний дэргэд зогсон ярилцаж тас тас инээнэ. (Ч.Л)                                       | 2. дэмий суухаар тэмээ хариул          |
| c. Дэндэв гуай, - За яахав ээ, ..... гэж бандийн ааган дээр миний хашрыг нэмэхэд эрхээ биш ганц нэг бухал овоолчих юм гогодчих байлгүй! гэв.(Д.У) | 3. бодовч бодын шийр дөрвөөс хэтрэхгүй |
| d. .... гэгчээр Итгэлтээс гуйхаас өөр арга олдсонгүй. (Ч.Л)                                                                                       | 4. олны олон таван цэн                 |
| e. .... гэгчээр жинчид гэв гэнэт зүгээр суух болсондоо уйтгарлан байж ядах болсон билээ. (Д.Н)                                                    | 5. галуу дуурайж хэрээ хөлөө хөлдөөнө  |

##### 1.2. Хэлцийн утгыг тунгаан цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.

- |                                                                                                                                     |                                                |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------|
| a. .... гэгчээр Данзан, Хүрэл, Дорж хоёроос бие хөлсөө авсан бөгөөд авчирсан зүйлсээ Хүрэлийн тусламжтайгаар борлуулсан ажээ. (Д.Н) | 1. тэмээ хариулсан хүн буурныхаа занг андахгүй |
| b. .... гэгчээр аманд сул орж байгаа юманд ганц эм хонь ч хаа юм бэ гэж Бадарч дотроо баярлан явжээ. (Ч.Л)                          | 2. үхсэн буурын толгойноос амьд ат айна        |
| c. .... гэгчээр энэ зүгт жаншлан ажих аваас манай тэнд юу болж байгааг нэгэн өчүүхэн хушуу хэмээн тоохгүй. (Ч.Л)                    | 3. чоно ойрхондоо ээлтэй                       |
| d. Их хүрээнээ суух зарлигийн сайд ..... гэгчийн үлгэрээр дэмий л хоосон сүр бадруулахаас өөр чадалгүй болсон цаг билээ. (Б.Р)      | 4. аз хүү байвал, ёоз хүүгээр хожно            |

е. Гэвч ..... гэгч хуучны цэцэн үгээр тэрхүү монголчуудын хардаж байсан манж сайдын чих тавин сонсох үг гэрч болж болзошгүй. (Б.Р)

5. явсан хүн яс зууна

**1.3. Хэлцийн утгыг тунгаан цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.**

- |                                                                                                                        |                                                      |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|
| а. Бадарчийн барзгар нүүрэнд ..... саран хайнагийн бүдүүн дуугаар орчмын бургасыг донслуулан инээв. (Ч.Л)              | 1. арсланг саваагаар алж                             |
| б. Итгэлтийн ширүүн үгэнд ..... байгаа Должинг шоолон, хорслын баяр бахдалаар сэтгэл нь дүүрч байлаа. (Ч.Л)            | 2. шуналын гал манаран оволзож                       |
| в. Тамгын газар заргалдвал залан авгайн ганц жинс нь манай хотын гурван айлаас ..... мэдэх л хэрэг гэж инээлдэв. (Б.Р) | 3. ачаа хүндэдсэн тэмээ шиг шургачин бууж өгч        |
| д. Заяагдсан амьдралаас хэтэрч ..... хагартал мөргүүлэх шахав гэж боддог болсон. (Ч.Л)                                 | 4. илүү жинтэй болчхож                               |
| е. Цагийг нь олж цохивол ..... болно гэж боддог хүн юм. (Ч.Л)                                                          | 5. бяруу болоогүй байж бухын хэрэлтээр хэрснээс болж |

**1.4. Хэлцийн утгыг тунгаан цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.**

- |                                                                                                                                                 |                                 |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|
| а. Дорнод уулын оройгоос цацарч байгаа нарны гэрэлд ивээгдсэн Тамирын хөндийн бөөн бөөн гялалзсан хар толбо ..... шиг өнхрөн тоглож байв. (Ч.Л) | 1. лянхуа цэцэг                 |
| б. Хуучны хуульч түшмэлийн нүдээр үзвэл энэ айлтгалын үг найруулга нь ..... багтамгүй найруулсан юм байна даа. (Б.Р)                            | 2. намрын хамхуул               |
| в. Төмөрийн зүрх баяр догдлолоор дүүрч сэтгэл нь доргиж байгаа ..... шиг чичирч байв.                                                           | 3. бүдүүн өвс                   |
| д. Энгийн номхон ардаас ..... авсан хүнийг хамгийн хатуу цээрлүүлнэ гэж Сүхбаатар өндөр дуугаар хэлэв. (Ч.Л)                                    | 4. чанга татсан утас            |
| е. .... шавраас гардаг гэгчээр Ням, Хишигт хоёроос ийм эрдэнэ төрдөг байжээ. (Ч.Л)                                                              | 5. сэтэрхий зүү, сиймхий самбаа |

**Алхам 2.** Доорх өгүүлбэрүүдийг солин найруулаад, холбох үгийг тайлбарлана уу.

Д/д	Онъсого	“Гэ-”, “хэмээ-” холбох үгсийн утга нь	Солин найруулсан нь
1	Дээрээс дэвс гэлээ. Дэлхий намс гэлээ. Хар хорхой атирав.	(дэвс) гэлээ – гэж дуугарлаа	Дээрээс дэвс хийж байгаа мэт чимээ гарлаа.


	Хадам эх уярав.	(намс) гэлээ – нам чимээгүй боллоо	Дэлхий нам гүм боллоо... гэх мэт
2	Тээ тэнд Тэс гэв. Тэвнийн үзүүр Гялс гэв.		
3	Атан тэмээ ангас гэнэ. Аргамжааны үзүүр гялс гэнэ.		
4	Түмэн бээрийн талбайд Цагаан хоргол асгав Түүж авъя гэсэн чинь Цалгиж халгиад явчхав.		
5	Хөвөн гэхэд ноолуургүй Хөнжил гэхэд захгүй Гурил гэхэд устай Ус гэхэд мөхлөгтэй.		
6	Даваагүй давааг дав гээд Даян холыг хүр гээд Далан чулууг бутан гээд Дэлхийн шороог хөдөлгө гээд.		
7	Нэг нь явъя гэж Нэг нь зогсъё гэж Нэг нь хэвтье гэж.		
8	Биегүй байтлаа Бүгдийг чирэх гэнэ.		
9	Цавчъя гэвч цав гарахгүй Чичье гэвч нүх гарахгүй.		
10	Хатгах гэвч цусгүй Хагалах гэвч ясгүй.		

**Алхам 3.** Хэлц үгсийн цэгийн оронд утгад тохирох “гэ-”, “хэмээ -” холбох үгсийг олж бичээрэй. Холбох үгийн хэлбэржилт өөр өөр байгаагийн учрыг ярилцаарай.

- |                |             |                       |                      |
|----------------|-------------|-----------------------|----------------------|
| 1. Ааш .....   | адасга      | Байхгүй .....         | дутахгүй             |
| 2. Айл .....   | арвага хийх | 6. Бага .....         | чамлахаар            |
| 3. Ам .....    | атлага шиг  | 7. Баруунш явах ..... | зүүнш явах           |
| 4. Баян .....  | байнга биш  | 8. Бэр сонгоё .....   | өглөө эрт            |
| 5. Байна ..... | илүүдэхгүй  |                       | Бэлчээр сонгоё ..... |
|                |             |                       | үд дунд              |

**Алхам 4.** "гэ", "хэмээ" үйл үгийн хэл зүйн утга, үүргийг тодорхойлж, өгүүлбэр дэлгэрүүлэх.

1. Үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөл
  2. Цагаар тодотгон холбох нөхцөл
  3. Цагаар төгсгөх нөхцөл
  4. Биеэр төгсгөх нөхцөл
  5. Үйлийн хэвийн дагавар
  6. Үйлийн байдлын дагавруудыг залган тус бүр 2 холбоо үг үүсгэж бичээрэй.
- Үлгэрлэвэл: ... **гэсэн сэтгэл** – “сэн” гэсэн өнгөрсөн цагаар тодотгон холбох нөхцөлөөр холбогдсон нэрийн холбоо үг.



**Алхам 5.** Үүсгэсэн холбоо үгээс 3 ыг сонгож “гэ-, хэмээ –” холбох үгээр холбон найруулсан өгүүлбэр зохиож бичнэ үү.

Холбоо үгс нь	Өгүүлбэр нь

Сурагчийн овог нэр: .....


Эхэлсэн ... он ... сар... өдөр ... цаг  
Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг



Хэлц өгүүлбэр нь ямар нэг гол санааг илэрхийлэх бөгөөд тэр нь аль нэг үйл явдлаас эхтэй байдаг. Үүнийг хэлцийн үүдэл санаа гэнэ.

### Дасгал 1. Өгөгдсэн хэлцийн гол ба үүдэл утга санааг таамаглан тайлбарлах


**Алхам 1.** Хэлцийн үүдэл санааг тайлбарлаарай. Монголчууд сайн эрийн шинжийг дараах байдлаар тодорхойлдог. Өгсөн хэлцийн утгыг ухаараад утга харгалзах дугаарыг тавина уу.



Хэлц өгүүлбэрүүд	Дугаар
- Сайн эр сарын хүлээцтэй	-
- Сайн эр замын уртад тэмүүлэх	-
- Эр хүн шиг эрвэлзэж, эмээлт морь шиг дэрвэлзэх	-
- Эр хүн нэг сэтгэлтэй бол эрдэнэ	-
- Тэмцэл дотроос баатар төрөх	-
- Аавын хүү явах тутам ухаан суудаг.	-

**Алхам 2.** Өгсөн хэлцийн утгыг ухаар. Үүдэл санааг таамаглаж, муу эрийн шинжийг загварын дагуу тодорхойлно уу.

- Адгийн эр авгайдаа баатар
- Муу эр дайнд хөөрөх, мунхаг хүн магтаалд хөөрөх
- Харгис гэгч муу эрийн явдал.
- Муу эрийн уур гэрээр дүүрэн.
- Муу эр архинд дурлах, сайн эр сургаалд дурлах.
- Сайн эр сарын хүлээцтэй, муу эр хоногийн хүлээцтэй.
- Их бороо зам эвдэх, их үг эрийг гутаах
- Ухнанд явсан хүү ямаа ишиглэсэн хойно ирэх



**Алхам 3.** Монголын эртний сургаалын зохиолд эмэгтэй хүнийг “Олонд сайхан ааль, эелдэг занг үзүүл. Хов үг танхилзуур инээдмийг тэвч. Хадам эцэг эхийг элбэрэн хүндэл. Уур хилэнг хүлцэж, айл аймагт сайхан зохиц. Садар эр, зусар эмийг бүү ойртуул.” хэмээн сургажээ. Энэхүү сургаалтай утга дүйх 5 - аас доошгүй хэлц олж бичнэ үү. Үлгэрлэвэл: “Сайн эхнэр сарын гурван баяр, муу эхнэр өдрийн гурван зовлон”, “Хэдгэнээс зугтсан үхэр хэцүү, хэрүүлд дуртай эм хэцүү” гэх мэт

- |         |                 |
|---------|-----------------|
| 1. .... | 4. ....         |
| 2. .... | 5. ....         |
| 3. .... | 6. .... ГЭХ МЭТ |

**Алхам 4.** Дараах хэсгүүдээс хэлцийг ялган тэмдэглээд, гол ба үүдэл санааг монголчуудын уламжлалт соёлтой холбож тайлбарлаарай. Үлгэрлэвэл:



**“Уруу нүүхэд бухан бяруу түрүүлэх”** гэсэн хэлцийн гол санаа нь “Ажлын хөнгөнд сээхэлзэх, сагсуурах” гэсэн утгатай бөгөөд монголчууд бярууг тэргэнд хөллөж сургахдаа эхний удаад хамгийн хөнгөн ачаа ачиж, үхэр тэрэгний цувааны араас дагуулж сургадаг байжээ. Тэргэнд сураагүй бяруу, уруу газар хөнгөн ачаатай тул цуваа эвдэж, хажуугаар нь түрүүлж орж ирээд байдаг байж. Үүнээс улбаалан ажил хийж сураагүй, дадлага туршлагагүй байтлаа толгой хаялан, сагсуурахыг энэ хэлцээр илэрхийлдэг болжээ.” гэх мэтээр тайлбарлана.

А

Голын тохойд ургасан ганц модыг харлаа гэхэд авьяас чадвартай нь түүнээс амар амгалангийн ярууслыг, арай дундаж нэг нь ганцаардлын ая, адгийн дорд нь гашуудал гуниг олж сонсоно. Олж харсан, сонссон, амталснаараа л хүний жаргал, зовлон хэмжигддэг.

Б

Хурааж цуглуулахын нэг зовлон, хумхиж хамгаалахын нөгөө зовлон, алдаж харуусахын адаг зовлон, ахуйд хүлэгдэхийн мянган зовлон.

В

Багш нь чамд нэг зүйл хэлье. Уур ухамсар хоёр нэг саванд багтдаггүй юм.

**А** Гол ба үүдэл санаа нь:

**Б** Гол ба үүдэл санаа нь:

**В** Гол ба үүдэл санаа нь:

**Алхам 5.** Өгсөн мэргэн сургаал буюу хэлцээр гол санаа илэрхийлэн харилцан ярианы хэлбэрээр өвөрмөц уран санаа бүхий эх зохиогоорой. **Үлгэрлэвэл:**

*Өвгөн: - Салхигүй шөнө нуурын уснаа тусах сар ямар вэ?*

*Залуу: - Тэнгэрт байгаагаасаа ч сайхан.*

*Өвгөн: - Салхитайд?*

*Залуу: - Хумхисан цаас хөвөх мэт.*

*Өвгөн: - Сар ямар вэ?*

*Залуу: - Ерөөсөө бол ч сайхан л даа.*

*Өвгөн: - Сайхнаар барах уу? Гагцхүү эгшин зуурын салхийг хэзээ ч намдахгүй юм шиг цухалдаж байдагт л хүний хамаг зовлон оршдог юм. (Д.Батбаяр)*

**Эхийн гол санаа нь:** “Гагцхүү эгшин зуурын салхийг хэзээ ч намдахгүй юм шиг цухалдаж байдагт л хүний хамаг зовлон оршдог юм.” гэдгээр илэрч байгаа бөгөөд энэ санааг илэрхийлэхийн тулд “Сар” хэмээх түлхүүр үгийг сонгожээ. Зохиомж нь өвгөн, залуу хоёрын сарны тухай хүүрнэл харилцан ярианы аргыг ашигласан байна.

**Эхийн гол санаа:** Уур бухимдал, шунал тачаал, гуниг гутрал бол салхины аясаар үүсэх давлагаа юм.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

## “ХЭЛНИЙ ЗҮЙН ХЭРЭГЛЭЭ” СЭДВИЙН СОРИЛГО

Сурагчийн овог нэр: .....

Эхэлсэн .... он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Их Нацагдорж шууд л утга уянгын яруу найргийг урсгаж эхлээгүй, харин баримтат –уран сайхны богино хэлбэрийн зохиолоор уран бүтээлээ туршин эхэлсэн, уран бүтээлдээ ул суурьтай хандсан гэж үзэх үндэстэй байна. Түүний зохиолуудыг ажиглахад:

“Берлин явсан замын тэмдэглэл”, “МИЮД”, “Майн нэгнийг хөрөнгөтний газар үзжээ”, “Хөдөө талын үзэсгэлэн” буюу “Амазонка”, “Шансонет”, “Гяндангийн шүлгүүд” гэх зэрэг баримтат- уран сайхны гэж үзэж болмоор хэдэн зохиол байна. Эдгээрээс хамгийн өвөрмөц сонирхолтой нь “Берлин явсан замын тэмдэглэл ” буюу “Улаанбаатараас Берлин хүртэл” (1927) хэмээх шүлэглэлт хүүрнэл зохиол юм. Энэ нь зэрвэс харахад, жижигхэн, ерийн л нэг таталбар юм шиг харагддаг. Гэвч “эх бичвэрт” нь задлал хийж нарийн ажиглавал сонирхолтой өвөрмөц зохиол. Нацагдоржоос өөрийн “зохиолчийн авьяас, мэдрэмж”-ээ шалгасан, сорьсон “нэгэн оролдлого, туршлага” гэмээр байдаг. Холын моринд дөрөөлж, улаалан одох замын эхэнд сэтгэл догдлон байхуй тэр торгон агшнаар аян замын тэмдэглэл эхэлж буй нь сонихон бөгөөд тэр эхлэл нь:

Тэр өдөр явахыг бэлтгэн завдаад, Энэ тэр лүгээ аяарлалцан ёслолцов. Өртөөний улааг дуудан хүлээлгэсэн бөгөөд Морин тэргэнээ сууж, баруун хойд зүг замнав. Хотын зах дор нэгэнт гармагц Алс замын үзүүр дор оров. Хойд давааг өгсөн шогшихуй дор Хол, ойр элдвийг санан бодон явав.	Энэ үе уул давааны энгэр дор Намрын шар наран жигдлэн тусаад, Мөн ар дор нимгэн цасан алагласан болохуйяа Эргэх цагийн улирлыг гайхан явав. Умард давааны орой улам улам ойртмогц Улаанбаатар хот улам улам холдон униартана. Урагш хэдэнт шогшиж, замыг дөхөөн Хойш хэдэнт харж, хот орноо санагалзан явав...
---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

**Улаанбаатар-Улан-Үдэ- Новосибирск- Москва – Ленинград – Берлин...**гээд аялах зам урт. Үргэлж өөр ертөнц, шинэ амьдрал, бодох сэрэх юм, гайхах бишрэх явдал олонт таарч тохиолдсоор... Тал хээрийн Монголын нутаг мэлцийм цэлгэр байснаа дайран өнгөрөх, угтан баясах гацаа тосгод, хот суурин, тариа ногооны газар цугаар хүний болж, үе үе үзэсгэлэнтэй сайхан уул далайтай учирч, нуур далайн уснаас загас жараахай үсрэн гарч, пол полхийх дуу чимээг гарган, цагаан саарал цахлай, салхич шувуун тэнгис далайг эзэгнэнхэн эргэлдэх нь гайхам сонин байж...Баримт- уран сайхан хосолсоор, зохиолчийн шинэ өгүүлэл зузаарсаар...Хил хязгаарын хот **Тройцарь хот – Галуут нуур – Өвгөн хэмээх газар – Үд хот – Байгаль нуур – Эрхүү хот – Улаан ярск (Красноярск) – Новосибирск хот – Киргизийн тал – Омск хот – Свердловск хот – Вятка хот – Москва – Ленинград – Берлин – Штетин хотын авто зогсоол...** гээд л хөвөрсөөр. Замын тэмдэглэл олон баримтаар баяжиж, зохиолчийн сэтгэл улам хурц болж, уран сайхан тоочилт, хүүрнэл, эргэцүүлэл, харьцуулал ундарсаар байгаа нь сонин. Баримтат-Уран сайхны тэмдэглэл хийж, зохиол бүтээнэ гэдэг бол тийм хам хум хийх зүйл биш байна гэдгийг Нацагдорж бие сэтгэлээр мэдэрч бичсэн нь их л өвөрмөц арга, туршлага болжээ...

Бас Нацагдорж маань энэ сэдвээр цэвэр уран сайхны нэг хувилбарыг таталбарлаж бичсэн нь “Алс газар сурахаар явагч” (1927) шүлэг юм. Энд нөгөө алдарт “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хөвгүүн эрдэнэ өвөртөлж харина” хэмээх юуны төлөө, яах гэж хол газар ирээд, юутай буцахаа бодож хэлсэн мөрүүдээ бичсэн юм. Тэр хүн, эгээрэл гэгээрлийн эрэлчин байжээ, эвий хөөрхий, Нацагдорж гуай!... (Б.Пүрэв-Очир “Их зохиолч Нацагдоржийн зарим баримтат уран сайхны зохиолын тухай”-гаас хэсэглэв.)





В. гэсэн, гэх, гэгчээр, гэвэл

Г. гэдэг, гэсэн, гэх, хэмээгч

9. “Алс замын үзүүр<sup>^</sup>дор оров.”, “Хойд давааг өгсөн шогшихуй<sup>^</sup>дор” гэсэн өгүүлбэрүүдэд байгаа зурж онцолсон үг: (2 оноо)

А. утга, үүрэг, хэлбэр адил

Б. утга ялгаатай, үүрэг, хэлбэр адил

В. зөвхөн хэлбэр адил

Г. утга, үүрэг адил

10. “Тэр өдөр явахыг бэлтгэн завдаад, энэ тэр лүгээ аяарлалцан ёслолцов.” гэсэн өгүүлбэрт байгаа “аяарлалцан” гэсэн үгийг ямар утгаар хэрэглэсэн бэ? (2 оноо)

11. “**аяарлалцан**” гэсэн үгийг бүтцээр зөв задалсан хэсгийг олоорой. (2 оноо)

А. аяар+л+лц+ө+н    Б. аяар+ ө+л+н    В. аяарла+лц+ ө+н    Г. аяар+лалц+н

12. **Хэлц бус өгүүлбэрт харгалзах хэлц өгүүлбэр олж бичээрэй.** (4 оноо)

А. Бүтэшгүй зүйлийг бүү мөрөөд.

Б. Өөрийн гэргүй айлаас айлд гэж явсаар.

В. Бүхнээс амттайг хүснэ.

Г. Сайн хүн замд аяндаа л таарна.

13. “**Үгийн дээж мэнд, хүндийн дээж хөөрөг**” хэмээх хэлцийн гол санаа нь (2 оноо)

А. Үг    Б. Мэнд    В. Дээж    Г. Хөөрөг

14. “**Мэдэхээс илүү эрдэмгүй**

**Мэндээс илүү жаргалгүй**” хэмээх хэлцэд (2 оноо)

А. Эрдэмгүй хүнийг өгүүлжээ.

Б. Мэддэггүй хүнийг өгүүлжээ.

В. Мэндтэй, мэдлэгтэй хүнийг өгүүлжээ.

Г. Жаргалгүй хүнийг өгүүлжээ.

15. **Хөхөө өвлийн** хүйтэн

Хөр цасны хатууг

Энх тунх даван туулж

Онд мэнд сайн оров уу? гэдгийн зурж онцолсон үгийн үүдэл санаа нь: (2 оноо)

А. Хөхөөн дуунаас үүдэлтэй

Б. Хөхөө сар гэсэн нэршилтэй холбоотой

В. Өвөл хөхөө байдаггүйтэй холбоотой    Г. Хөх өнгөтэй холбоотой.

16. Харгалзуулсан өгүүлбэрийн аль нь найруулгын хувьд оновчтой байна вэ? Оновчтой хэмээн үзэж буйгаа сонгож дугуйлна уу. (3.5 оноо)

1. Хоёрдугаар байранд 300 орчим оюутан амьдардаг.	1. Хоёрдугаар байранд 300-аад оюутан сурдаг.
2. Хүний гар харахааргүй болсон эмэгтэйчүүд	2. Амьдрал нь хэнээс ч хараат бус эмэгтэйчүүд.
3. Латвийн бөхийг цэвэр давсан.	3. Латвийн бөхийг цэвэр ялсан
4. Та энэ асуудалд хэрхэн хандаж байна вэ?	4. Та энэ асуудлыг юу гэж үзэж байна вэ?
5. Задгай сансарт гарч дөрвөн удаа ажиллана.	5. Сансарт дөрвөн удаа ил гарч, ажиллана.
6. Нөгөө Цэцэг чинь сэтгэлээр их унасан байна.	6. Нөгөө Цэцэг чинь бүр урвайж гүйцжээ.
7. Зарим нь сүрхий шидэж байгаа харагддаг.	7. Зарим нь хүчтэй шидэлт хийж харагддаг.



**Дасгал 1. Асуудал дэвшүүлсэн нийтлэл эхийг задлан шинжилье.**

Сурагчийн овог нэр: ...

Эхэлсэн ...он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг



Нийгмийн амьдралаас аливаа асуудлыг олж дэвшүүлдэг, үйл явдлыг оюун ухаанаар тунгаан шүүж үнэлж, дүгнэж, эргэцүүлж, тайлбарлаж, тоочиж, дүрсэлж бичих зэрэг төрөл бүрийн аргыг хослуулсан эхийг нийтлэл эх гэнэ. Зарим нийтлэл эх нь бодрол бясалгалын өнгө аясыг баримттай хослуулдагаараа эсээ бичвэртэй төстэй.

**Нулимстай бөхөн**

Хүйсийн говийн адаг Шаргын говийн эхэн. Амсхийх чөлөөгүй хүйтэн хавсарга говийн бударганат бор талыг тэр чигт нь хийсгэчих шахан тачигнана. Цас багатай жил болоод ч тэр үү их говийн уудам тал нэлэнхүйдээ бараантана. Дүнсгэр говийг жилийн өдийд сэргээж, амилуулдаг цөөхөн зүйлийн нэг нь бөхөн.


Гэвч хорь гаруйхан хоногийн дотор хоёр, гурван мянган бөхөнгөө “алдсандаа” их говь улам бүр бараантан байх шиг... Ийн бодол тээн бөхөнгийн орон гэгдэх нутгаар нэгээхэнтэй ч тааралгүй хоёр цаг гаруй давхисны эцэст хамт яваа хүмүүсийн нэг “Тэрийг хар аа, ашгүй дээ” гээд ухасхийв. Заасан зүгт нь цагаан тоос татжээ. Говь амилах шиг болж, их талын дунд зургаан цагаан тоос татсан нь зургаан бөхөн цахилж одсоныг илтгэнэ. Машины чимээнээр харваж одсон зургааг мялзангийн халдвар аваагүй учраас л ийн цовоо цахилсан биз хэмээн ярьж дуусаагүй байтал жолооч огцом тоормос гишгэн зогслоо. Ташуурдах жавраас нөмөрлөх нь битгий хэл өчүүхэн ч нэмэр болохооргүй сэрийсэн давжаа загийн хажууд үргэж одох нь битгий хэл өндийх ч тэнхэлгүй янзага аахилан хэвтэж байв. Дэргэд нь очсон биднээс цочдосхийснээ толгойгоо өргөж үл дийлэн тийчлэх янзаганы хоёр нүднээс урссан нулимс, нуух дарайн хөлдөж, хойд хөл, цавь нь тэр чигтээ хар ногоон чацгаар будагдсан нь мялзан төст өвчинд дийлдэж буйг нь илтгэнэ. Их говийн заг, бударгана болгоноор салхины нөмөр хийн амь тийчлэн хэвтэж буй зуу зуун янзаганы нэг нь тэр. Түүнийг ингээд орхивол бусдадаа амьсгалын замаар халдвар тараана.

Жавар тачигнасан хүйтэн талд хэзээ үхэхийг нь хүлээн суух боломжгүй тул зориулалтын уутанд хийгээд устгалын цэгт хүргэхээс өөр аргагүй. Энэ бол Шаргын говийн их тал эхлэхээс арваадхан километрийн цаана буюу одоогоор 3000 гаруй бөхөнгийн амийг авч одоод байгаа мялзан өвчний голомт Хүйсийн говийн нутаг. Хүйсийн говьд өнгөрсөн оны байдлаар 6000 гаруй бөхөн байсан бол өдгөө тал нь үрэгдээд байгаа. Харин ажлын хэсгийнхэн одоогоор эрүүл хэмээн тооцож буй Шаргын говь руу өвчтэй, халдвартай бөхөнг нэвтрүүлэхгүй, эрүүлийг халдварын голомт руу оруулахгүйн тулд эргүүлийн есөн пост гарган байнгын үргээлгэ хийж байгаа юм. Гэхдээ эх болон бусдаасаа тасарч хоцорсон түрүүчийн янзага мялзан өвчний аюул Шаргын говийн хаяанд ирсний дохио. Одоо хамгийн чухал нь Шаргын говьд эрх дураараа бэлчиж буй 5000 гаруй бөхөнд халдвар тараахгүй байх юм. Хэрвээ энэ бүсэд халдвар орвол монгол бөхөн тэр чигтээ үгүй болох эрсдэлтэй. Дэлхийд нэн ховор, хэдэн зуун сая жилийн тэртээгээс өдгөөг хүртэл тэсэж үлдсэн цор ганц амьтан хэмээгддэг монгол бөхөнгийн сүрэгт учирсан халдварт өвчний аюул, эрүүлийг нь хамгаалж, сэргийлэхийн тулд Засгийн газар хийгээд орон нутгийн албан хаагчид, ард иргэд хэрхэн ажиллаж байгааг сурвалжлахаар Говь-Алтай аймгийг зорьж очоод байгаа нь энэ....

(Б.Энхмарт. 2017. “Үндэсний шуудан” сонин)

**Үгийн утга: Бөхөн** - Тугалмайтан овгийн, говь тал, бэл газар сүргээр амьдардаг, шаргалдуу зүстэй, шоорон эвэртэй, хэвдэг, хос туруутан амьтан.





**Алхам 5.**

а. Дараах асуулт тус бүрд нэг нэг өгүүлбэрээр хариулж бичил эх бүтээнэ үү.

**Нулимстай бөхөн**

юу? .....

хэзээ? .....

хаана? .....

яагаад? .....

яав? .....

б. Зохиогч дээрх асуудлыг шийдэх арга замыг санал болгосон хэсгийг эхээс ялгаж бичнэ үү.

.....



**Дасгал 2. Уншигч, зорилго, нөхцөл байдалдаа тохирсон бүтэц хэв маягийг сонгон нийтлэл бичье.**

Сурагчийн овог нэр: ...

Эхэлсэн ...он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**Алхам 1.** Бичихийн өмнө. “Нулимстай бөхөн” нийтлэлийг тодорхойлъё. **Үлгэрлэвэл:** Уран өгүүллэгийн их мастер Ж.Лхагвын өгүүллэгийн түүврийн өмнөх үг “Чандманийн түлхүүр” хэмээх эхийг нэрт зохиолч Д.Урианхайн бичсэнийг дараах байдлаар тайлбарлаж болно.

**Зохиогч ямар зорилгоор бичсэн:** Зохиолч Д.Урианхай нь, зохиолч Ж.Лхагвын түүвэр зохиолын өмнөх үг болгож сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлж бичсэн.

**Ямар уншигчид зориулж бичсэн:** Зохиолчийн уран бүтээлийг уншигчдад зориулсан.

**Уншигчийн сэтгэл хөдөлгөх ямар үг хэллэг, дүрслэл ашигласан (5 – аас доошгүй жишээ):** ... бодож явсан андууг минь “Толгодын цаана ингэ буйлна.” хэмээх энэ боть хамхуул хийсгэх мэт хийсгэж ... гэх мэт.

**Тоочимж, хүүрнэмж, тайлбарламж, эргэцүүлэмж хэв маягийг хэрхэн хослуулсан (Тус бүр хэдэн хувь орчим):** ..... ээс ..... р өгүүлбэр тоочимж, ..... ээс .....р өгүүлбэр хүүрнэмж. Дийлэнх буюу ..... орчим хувь нь тайлбарламж гэх мэтээр ажиглаж тоймлож бичнэ.

<p>Зохиогч ямар зорилгоор бичсэн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>Ямар уншигчид зориулж бичсэн:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>Уншигчийн сэтгэл хөдөлгөх ямар үг хэллэг, дүрслэл ашигласан (5 – аас доошгүй жишээ):</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>Тоочимж, хүүрнэмж, тайлбарламж, эргэцүүлэмж хэв маягийг хэрхэн хослуулсан (Өгүүлбэрийн заагийг дурдаж, тус бүр хэдэн хувь орчим байгааг баримжаалах):</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>



**Алхам 2.** Дараах өгөгдлийн дагуу бичил нийтлэл бичнэ үү.

Ямар уншигчид зориулж бичих вэ?	Ямар сэдвээр	Ямар зорилгоор бичих вэ?	Эхийн хэв маяг, бүтэц ямар байх вэ?
Ямар нэг сонин, эсвэл аль нэг онлайн сайтын уншигчдад	Амьдарч буй газрынхаа хог хаягдал түүнийг хэрхэн шийдвэрлэх арга зам	Сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлэх зорилгоор	- Хүүрнэмж - Тоочимж - Тайлбарламж - Эргэцүүлэмж хослуулах

**Нийтлэлийн бүтэц, төлөвлөгөө:**

**Эхлэл хэсэг:** Орчин тойрны хог хаягдлаас шалтгаалж болсон нэг бодит жишээ, болсон явдлыг **сонирхолтой, уран сайхан тоочиж, хүүрнэж бичиж эхлэх.**

.....

.....

.....

.....

.....

**Гол хэсэг:** Дээрх үйл явдлаас үүдэн, хог хаягдал гэж чиний бодлоор юу болох, бусад хүмүүс юу гэж үздэг, танай гэр бүлийнхэн болон ангийнхан хог хаягдалд яаж ханддаг, ямар асуудал байгаа тухай **товч тодорхой тайлбарлаж, эргэцүүлж бичих.**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

**Төгсгөл хэсэг:** Асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга зам, гарцыг санал болгож, өөрийн **үзэл бодол, дүгнэлт, эргэцүүллээр төгсгөх.**

.....

.....

.....

.....

.....

.....

**Дасгал 1. Ятгасан эсээг задлан шинжилье.**

Сурагчийн овог нэр: ...

Эхэлсэн ...он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**Ятгасан эсээ:** Ямар нэг дэлгэрэнгүй тайлбар шаардахгүй. Өөрийн хэлэх гэж буй санааг мэтгэлцэх байдлаар шууд баримт болон элдэв аргаар дэмжин уншигчийг ятгах, итгүүлэх зорилго агуулдаг. Дэвшүүлсэн асуудлаа батлахдаа итгэтэл бичихийг хэлнэ..

**Алхам 1.** Зохиолч П.Батхуягийн “БОРЦ” эсээг 2 - 3 удаа анхааралтай уншина уу.  
(Хавсралтаар өгсөн.)

**Алхам 2.** Эхээс дараах үгийн утгыг тайлбар толь ашиглан тайлбарлана уу.

1. Тарчиг цаг -----
2. Холио солио хийх -----
3. Хар тагш -----
4. Элэнц -----
5. Хуланц -----
6. Өмнөд туйл -----
7. Цөмийн физик -----
8. Нано технологи -----
9. Кавказ -----
10. Барбикью -----

**Алхам 3.** Эсээний эхлэл хэсгийг дахин уншина уу. Эсээг ямар аргаар эхэлсэн бэ? Зөвийг тодруулан тэмдэглээрэй.

Хаврын ялимгүй тарчиг цагаар борцтой холбоотой дурсамжгүй нэг ч монгол хүн байхгүй гэдэгт би итгэдэг. Үүдний амбаарт өлгөсөн борцноос хоёр годгорыг авч цүнхлээд хичээлдээ явдаг байлаа. Сургууль орох замдаа зажилсаар идэж дуусгана. Заримдаа “танай борц амттай, манайх амттай” гэлцээд сургууль орох замдаа ангийнхаа хөвгүүдтэй холио солио наймаа хийнэ. Хөгшчүүл “түүхий борц идээд цагаан хорхойтой болно доо” гэж анхааруулах ч үл тооно. Тэгээд хэлсэн ёсоор нь цагаан хорхойтно. Хичээлд олон цагаар суух л жаахан хэцүү. Суудал дээрээ хавчигнахыг үзүүлнэ дээ. Харин орой нь нүдэж нунтагласан борцтой гурилтай шөл голдуу хийсэн байх. Хар тагшиндаа дүүргэж аваад бор ходоодоо божийлгоно. Өглөө нь борц хөвүүлсэн будаатай цайны үнэрээр сэрнэ. Өлбөрч өлсөж үзээгүй өссөн гэлээ ч борц гэдэг хатсан бор махны амт хүүхэд насны гэгээн бодол дурсамжийн нэгээхэн хэсэг болж хадгалагджээ. Эмээ минь дээлийнхээ хормой дээр борц жижиглээд тогоотой усанд хийж самарна. Удалгүй гэр дүүрэн ер бусын гойд сайхан хоолны үнэр ханхална.

Эшлэлээр	
Асуултаар	
Дүгнэлт , баталгаа нотолгоогоор	
Таамаглалаар	
Баримтаар	
Болсон явдал товч түүх ашиглаж	
Дурсамж яриагаар	
Эсрэг санаа буюу нөхцөлөөр	

**Алхам 4.** Зохиогчийн дэвшүүлсэн асуудал, эсээндээ хэлэх гэсэн санаа 2 дугаар догол мөрт илэрчээ. Чухам аль өгүүлбэрт байгааг сонгож тэмдэглэнэ үү.

**а.** Хэдийгээр он цагийг нь бүрэн тогтоож одоо хүртэл чадаагүй ч өвлийн эхээр махаа борцлоод хаврын уртад хүнсэндээ хэрэглэдэг Монголчуудын энэ уламжлалт арга ухаан даруй 3000 жилийн түүхэнд тэмдэглэгджээ. Эртний Хятадын түүхийн сурвалж бичигт талын нүүдэлчид хүнсэндээ хатаасан мах хэрэглэдэг тухай бичсэн байдаг гэнэлээ.

**б.** Өвөө, өвөөгийн өвөө, бүр элэнц хуланцын үеэсээ бид махаа борцолж ирсэн байх нь. Одоо ч махаа борцолсоор л байна. Магадгүй ирээдүйд ч борцолно. Үл тасрах өв уламжлал, арга ухаан гэдэг нь ёстой энэ буюу.

**в.** Энэ л урь идүүлж хатаасан махны талаар үнэн худал нь мэдэгдэхгүй олон янзын сонин хачин зүйл уншиж, сонсож явлаа.

**Алхам 5.** Зохиогч эсээндээ монголчуудын хоол хүнс түүний дотор “БОРЦ” - оор дамжуулан ямар асуудлыг дэвшүүлсэн бэ?

.....  
.....  
.....

**Дасгал 2.** Ятгасан эсээнд баримт нотолгоо, уншигчид нөлөөлөх дүрслэл, эшлэл зүүлт ашиглан байр сууриа илэрхийлснийг задлан тайлбарлая.

Сурагчийн овог нэр: ...


Эхэлсэн ....он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**Алхам 1.** “Эртнээс нааш бэлтгэж хоол хүнсэндээ хэрэглэж ирсэн “борц” бол монголчуудын хувьд хамгийн шим тэжээлтэй хоол хүнсний зүйл юм.” гэсэн санааг итгүүлэн үнэмшүүлэхийн тулд уншигчийн сэтгэлд нөлөөлөх үг хэллэг ашигласан 5 – аас доошгүй өгүүлбэрийг ялгаж бичнэ үү. Ялгасан өгүүлбэр дотроос хамгийн чухал гэж үзэж буй хэсгийн доогуур зурж тэмдэглээрэй.

1. ....  
.....
2. ....  
.....
3. ....  
.....
4. ....  
.....
5. ....  
.....

**Алхам 2.** Ятгасан эсээнд ашигласан баримтуудыг ялган танья. Дараах баримтын төрөл тус бүрд тохирох нэг жишээг олж бичнэ үү.



**Алхам 3.** Зохиолч П.Батхуяг уг бичиж буй зүйлдээ ёс зүйтэй хандсаныг жишээгээр батална уу. **Үүнд:**

**1. Дам эх сурвалжаас авсан гэдгээ ямар үг өгүүлбэрээр илэрхийлсэн бэ? Тэдгээрийг дараах хэсгүүдийн дотроос ялган зурж, тодруулж тэмдэглэнэ үү.**

**а.** Монголчуудын талаарх Хятадын эртний нэгэн түүхэн бичигт “тэдний хатааж ууталсан махыг олбоос хүнсэндээ хэрэглэж болно. Гэвч хоолондоо чимхийн төдий хийвээс зохилтой. Нэгэн удаа манай цэргүүд тэр махыг олж хэтрүүлэн хэрэглээд олноор гэдэс мушгирч үхэв.” хэмээн бичсэн байдаг тухай эрдэмт ахаасаа сонсож байв.


**б.** Мөн Хубилай хааны усан флот Япон тэнгист сүйрээд олон жилийн дараа уснаас гаргаж авсан жижиг арьсан богцны доторхийг шинжилбээс борц мах хадгалж байсан нь тогтоогдсон гэдэг юм. Хойлогны мах хүртэл борцолж хатаагаад холын замдаа авч яваад харь дайсны мэсний шарх олсон үедээ идэж, хэдхэн өдөрт тэнхрэн босдог байжээ. Энэ тухай бүр Чингис хаан зарлиг болсон мэдээ баримт ч бий гэнэ лээ.

**г.** Миний мэдэхээр цаг уурын инженер Ж.Цэрэнпэлэг гуай л тэнд очиж ажиллаж, амьдарч байхдаа олон улсын эрдэм шинжилгээний багийнхандаа борцтой шөлөө хийж өгөөд, өнөөдүүл нь амт шимтийг нь шагшин магтаж гадны тэр олон судлаачид Монголчууд биднийг бишрэн хүндэлсэн гэдэг.

**2. Уншигчийг хүндэтгэж, өөрийгөө хэтийдүүлэн дөвийлгөөгүйг ямар үг хэллэгээс харж болох вэ? Ялган зурж тэмдэглэнэ үү.**

Түүхэн хэл зүйн талаасаа” борц-борш” хоёр шууд холбоотой гэж би хэлж мэдэхгүй. Бас манай борцтой шөлний нэр тэнд тэгж хувираад явж буйг хэн үгүйсгэж чадах билээ. Лав л орос хэлний толь бичигт борш гэдэг үгийн гарлыг тодорхой хэлсэн зүйл, тодорхой утга байхгүй. Түүхэнд нь ч тэр 13-р зууны үеэс холбогдуулж бичсэн байдаг юм. Украин, Польш хавиар дэлгэрсэн борш шөлийг яаж хийдгийг нь сонирхоод харж байхад яах аргагүй л манай талын тос өөх, холио хутгаа л яваад байх шиг байдаг юм. Эрхэм мэргэн уншигч та бүхэн энэ этгээд ёстой хальж хатуурч байна даа гэж бодож байж болох юм.


3. Эсээний нотолгоо нь үнэн бодитой, баттай эх сурвалжаас авсныг ямар ямар баримт харуулж байна вэ? Баримтуудыг товч тоймлон нэрлэнэ үү.  
(Дараах 8 хэсэгт тохируулан нөхөж бичнэ.)



**Алхам 4.** Эсээнд уран тод дүрслэлээр уншигчийн анхаарлыг татсан 6 жишээг олж ерийн утгаар хувиргаж бичнэ үү.

1. -----
2. -----
3. -----
4. -----
5. -----
6. -----

**Алхам 5.** Эсээнээс ерөнхий сэдэв – тодорхой сэдэв – түүгээр дамжуулан дэвшүүлсэн асуудал – эсээний гол санааг оновчтой тодорхойлно уу.



**Алхам 6.** Эсээний задлалаа нэгтгэн дүгнээрэй.

	П.Батхуяг “ Борц” эсээ
Зохиогч ямар сэдвийг сонгож, ямар шийдэл санал болгож бичсэн бэ?	
Зохиогч эсээгээр дамжуулан уншигчийг юунд итгүүлэх зорилго тавьсан бэ?	
“Миний номын агуулга тэр чигээрээ би өөрөө” – гэсэн М. Монтений үгийг батлах хэсэг уг эсээний аль хэсэгт байна вэ? Жишээ татаж товч тайлбарлана уу.	
Зохиогчийн ятган итгүүлэх зорилгод тулгуурлан түүнээс сонирхол татах гурван асуулт асууна уу.	<p><b>Асуулт 1:</b></p> <p><b>Асуулт 2:</b></p> <p><b>Асуулт 3:</b></p>
Уул эсээг уншаад төрсөн сэтгэгдлээ нэг өгүүлбэрээр илэрхийлнэ үү.	
Энэхүү эсээг зохиогчийн санааг давтахгүйгээр өөрийнхөөрөө дүгнэнэ үү.	

**Дасгал 3. Ятгасан эсээ бичье.**


Сурагчийн овог нэр: ...

Эхэлсэн ....он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**Алхам 1. Бичихийн өмнө дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.**

Та нарт ямар эх итгэл үнэмшилтэй санагддаг вэ? Тэдгээрт ямар нийтлэг шинж чанар байдаг вэ? Мөн ямар зүйлс худал санагддаг вэ? Тэдгээрт ямар нийтлэг шинж чанар байдаг вэ? Сурах бичгээ эргэн үзэж, тунгаан бодоод доорх асуултад хариулна уу.

	Итгэмээр бичсэн эхэд ямар шинж байдаг вэ? - - - - - -	Итгэл үнэмшилгүй бичсэн эх ямар шинж чанартай байна вэ? - - - - - -
-----------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------

**Алхам 2.** Та нар уншигчийг итгүүлэн үнэмшүүлэх зорилготой ятгасан эсээ бичжээ. Чиний бичсэн эсээ ямар шалгуурыг хангавал зохих вэ? Найман шалгуур гаргана уу.

1. -----
2. -----
3. -----
4. -----
5. -----
6. -----
7. -----
8. -----

**Алхам 3. Эсээгээ ерөнхийд нь төлөвлөө. Дараах төлөвлөгөөг гүйцээгээрэй.**

Ямар зорилгоор бичих вэ?	Ямар уншигчид зориулж бичих вэ?	Уншигчийн сэтгэл хөдөлгөх, анхаарлыг татах ямар үг хэллэг, дүрслэл ашиглаж болох вэ? Холбоо үгийн жишээ бичнэ.	Эхийн хэв маяг, бүтэц ямар байх вэ?
Этгээд, бүдүүлэг үг хэллэгийг хэрэглэх нь хүмүүсийн харилцаанд сөргөөр нөлөөлдгийг ухааруулах	12 дугаар ангийнханд зориулна.	..... ..... ..... ..... ..... .....	- Хүүрнэмж - Тоочимж - Тайлбарламж - Эргэцүүлэмж хослуулах

**Этгээд, бүдүүлэг үг хэллэг гэж юу вэ?** Ажил мэргэжлийн гэх мэт нийгмийн явцуу хүрээн дэх харилцааны үед тухайн бүлэг хүмүүст тусгайлсан үг хэллэг бий болдог. Чамирхаж маяглах, дэгжирхэх, онгирч сагсуурах, танхайрах, харилцагчаа үл хүндэтгэх, нууцлах, явцуурах гэх мэт хувь хүний зан байдлаас шалтгаалан этгээд үг хэллэг гарах нь бий. Хэтэрхий ширүүн, эелдэг бус, хүмүүсийн харилцаанд харш, утга зохиолын хэлнээ хэрэглэхгүй үг хэллэгийг бүдүүлэг үг хэллэг гэдэг. Доромж утгатай юм уу, хараал зүхлийн үг хэллэгийг үүнд хамааруулж үздэг.

**Алхам 4. Бичихийн өмнө дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.**

а. Эсээндээ өвөрмөц содон нэр өгнө үү.

.....

б. Асуудлаа дэвшүүлнэ үү.

.....

.....

.....

в. Эсээнийхээ хөтөч өгүүлбэрийг бичнэ үү.

.....

.....

.....

г. Өгүүлбэрүүдийн цэгийн оронд тохирох үгсийг нөхөж бичээрэй.

**НӨХӨЖ БИЧИХ ӨГҮҮЛБЭРҮҮД**

1	Би этгээд, бүдүүлэг үг хэллэгийг хэрэглэх нь хүмүүсийн харилцаанд сөргөөр нөлөөлдгийг ухааруулах зорилгоор ятгасан эсээ бичихдээ ..... ..... гэсэн асуултад хариулж чадвал уншигчид итгэл үнэмшил төрүүлж чадна гэсэн үг.
2	Би ..... ыг итгүүлэн үнэмшүүлэхийн тулд ..... талаар урьдчилан ..... байх хэрэгтэй.
3	Ятган итгүүлэх нь .....-тэй адилгүй. Ятган итгүүлэх нь ..... гэсэн үг.

**Алхам 5.** Ятгах зорилго бүхий дурын 2 өгүүлбэр зохиосныхоо дараа баймж үг, чимэх үг, эрчимжүүлсэн тэмдэг нэр зэргээр дэлгэрүүлэн найруулж бичээрэй. Эдгээр нь ятган үнэмшүүлж бичихэд хэрхэн нөлөөлж буйг хүснэгтийн эцэст дүгнээрэй.

Д/д	Зорилго	Зохиосон өгүүлбэрүүд нь	Баймж үг, чимэх үг, эрчимжүүлсэн тэмдэг нэр оруулан найруулсан нь	Ялгаа, нөлөө
1	Ятган итгүүлэх			
2				



#### Дасгал 4. Ятгасан эсээ бичье.

Сурагчийн овог нэр: ...

Эхэлсэн ....он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

#### Алхам 1. Бичил эсээ бичье.

**Юуг ятган итгүүлэх вэ?** Этгээд бүдүүлэг үг хэллэг нь тухайн хэлний үг хүрэлцээгүйгээс үүсэж бий болдоггүй, утга зохиолын хэлний хэм хэмжээг гажуудуулсан үг хэллэг байдаг тул хэрэглэгч хүмүүсийн боловсрол дээшлэх тусам ийм үг хэллэгийн хэрэглээ багасдаг. Этгээд, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх нь боловсрол соёлын түвшин дорой, харилцааны соёлгүй гэдгээ харуулж буй тул зохисгүй хэрэг юм гэдгийг итгүүлэх зорилгыг агуулж бичнэ.

Бусадтай давтагдахгүй өвөрмөц сонин санаагаар эсээнийхээ хөтөч өгүүлбэрийг бичиж, асуудлаа дэвшүүлж эхэлнэ үү.

.....

.....

.....

Дэвшүүлсэн асуудлаа дэмжих цогцолборт этгээд ба бүдүүлэг үг хэллэгийн хэрэглээний тухай үндэслэл, баримт нотолгоо бичнэ үү. Өөрийн сургууль, анги танхимын орчны жишээ татна уу.

.

.....

.....

.....

Үг хэллэгийн хэрэглээний тухай өөрийн үзэл бодлыг ятган итгүүлж, баталж нотолж бичнэ үү.

.....

.....

.....

.....

.....

.....

.....


Эсээнийхээ дэвшүүлсэн асуудлын шийдлийг санал болгож, дээрх хэсгүүдтэйгээ үялдаа холбоотой дүгнэж бичнэ үү.

.....

.....

.....

## Өөрийн үнэлгээний зураглал






## Өөрийгөө үнэлье.

### Өөрийгөө үнэлэхдээ юу анхаарах вэ?

Та нар дасгал ажлын дэвтрийг “Нийтлэл”, “Ятгасан эсээ” гэсэн хоёр бүлэг сэдвийн хүрээнд гүйцэтгэж дууссан. Дээрх өөрийн үнэлгээний зураглалд гүйцэтгэсэн ажлын нарийвчилсан зураглалыг гаргасан байна. Тэдгээрийг хэрхэн гүйцэтгэсэнээ нэг бүрчлэн тэмдэглэснийхээ дараа доорх ерөнхий үнэлгээг хийгээрэй. Гүйцэтгэлээ бүрэн гүйцэд, багшаас өгсөн хугацаанд багтаж чанартай, зөв хийснээ эргэцүүлэн бодоорой.

Сурагчийн овог нэр: ...

Эхэлсэн ...он ... сар... өдөр ... цаг  
Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

№	Эзэмших чадвар	Эхэлсэн	Дууссан	Өөрийн үнэлгээ (+ тэмдгээр)			Багшийн үнэлгээ
							
<b>Бүлэг сэдэв 1: Нийтлэл</b>							
1	Асуудал дэвшүүлсэн нийтлэл эхийг задлан шинжилье.						
2	Уншигч, зорилго, нөхцөл байдалдаа тохирсон бүтэц хэв маягийг сонгон нийтлэл бичье.						
<b>Бүлэг сэдэв 2: Ятгасан эсээ</b>							
3	Ятгасан эсээг задлан шинжилье.						
4	Ятгасан эсээнд баримт нотолгоо, уншигчид нөлөөлөх дүрслэл, эшлэл ззүлт ашиглан байр сууриа илэрхийлснийг задлан тайлбарласан						
5	Ятгасан эсээ бичихэд бэлтгэсэн						
6	Бичил эсээ бичсэн						

**12 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ БИЕ ДААН СУРАЛЦАХ АЖЛЫН ДЭВТРИЙН  
ЗАМЫН ЗУРАГЛАЛ: Танин мэдэхүйн түвшнээр**

Бүлэг сэдэв	Ажлын хуудас	Ажлын хуудасны дугаар	Танин мэдэхүйн түвшин		
			Мэдэх, ойлгох	Задлан шинжлэх	Үнэлэх, бүтээх
Нийтлэл	Асуудал дэвшүүлсэн нийтлэл эхийг задлан шинжлэх	1			
	Уншигч, зорилго, нөхцөл байдалдаа тохирсон бүтэц хэв маягийг сонгон нийтлэл бичих	2			
Ятгасан эсээ	Ятгасан эсээг задлан шинжлэх	1			
	Ятгасан эсээнд баримт нотолгоо, уншигчид нөлөөлөх дүрслэл, эшлэл зүүлт ашиглан байр сууриа илэрхийлснийг задлан тайлбарлах	2			
	Ятгасан эсээ бичих	3 – 4			
	Бүлэг сэдвийн үнэлгээ дүгнэлт				

## **Хавсралт: Унших эсээг тусад нь өгнө.**

П. БАТХУЯГ “БОРЦ”

(Эсээ)

Хаврын ялимгүй тарчиг цагаар борцтой холбоотой дурсамжгүй нэг ч монгол хүн байхгүй гэдэгт би итгэдэг. Үүдний амбаарт өлгөсөн борцноос хоёр годгорыг авч цүнхлээд хичээлдээ явдаг байлаа. Сургууль орох замдаа зажилсаар идэж дуусгана. Заримдаа “танай борц амттай, манайх амттай” гэлцээд сургууль орох замдаа ангийнхаа хөвгүүдтэй холио солио наймаа хийнэ. Хөгшчүүл “түүхий борц идээд цагаан хорхойтой болно доо” гэж анхааруулах ч үл тооно. Тэгээд хэлсэн ёсоор нь цагаан хорхойтно. Хичээлд олон цагаар суух л жаахан хэцүү. Суудал дээрээ хавчигнахыг үзүүлнэ дээ. Харин орой нь нүдэж нунтагласан борцтой гурилтай шөл голдуу хийсэн байх. Хар тагшиндаа дүүргэж аваад бор ходоодоо божийлгоно. Өглөө нь борц хөвүүлсэн будаатай цайны үнэрээр сээрнэ. Өлсөж үзээгүй өссөн гэлээ ч борц гэдэг хатсан бор махны амт хүүхэд насны гэгээн бодол дурсамжийн нэгээхэн хэсэг болж хадгалагджээ. Эмээ минь дээлийнхээ хормой дээр борц жижиглээд тогоотой усанд хийж самарна. Удалгүй гэр дүүрэн ер бусын гойд сайхан хоолны үнэр ханхална.

Хэдийгээр он цагийг нь бүрэн тогтоож одоо хүртэл чадаагүй ч өвлийн эхээр махаа борцлоод хаврын уртад хүнсэндээ хэрэглэдэг Монголчуудын энэ уламжлалт арга ухаан даруй 3000 жилийн түүхэнд тэмдэглэгджээ. Эртний Хятадын түүхийн сурвалж бичигт талын нүүдэлчид хүнсэндээ хатаасан мах хэрэглэдэг тухай бичсэн байдаг гэнэ лээ. Өвөө, өвөөгийн өвөө, бүр элэнц хуланцын үеэсээ бид махаа борцолж ирсэн байх нь. Одоо ч махаа борцолсоор л байна. Магадгүй ирээдүйд ч борцолно. Үл тасрах өв уламжлал, арга ухаан гэдэг нь ёстой энэ буюу. Энэ л урь идүүлж хатаасан махны талаар үнэн худал нь мэдэгдэхгүй олон янзын сонин хачин зүйл уншиж, сонсож явлаа.

Монголчуудын талаарх Хятадын эртний нэгэн түүхэн бичигт “тэдний хатааж ууталсан махыг олбоос хүнсэндээ хэрэглэж болно. Гэвч хоолондоо чимхийн төдий хийвээс зохилтой. Нэгэн удаа манай цэргүүд тэр махыг олж хэтрүүлэн хэрэглээд олноор гэдэс мушгирч үхэв” хэмээн бичсэн байдаг тухай эрдэмт ахаасаа сонсож байв. Мөн Хубилай хааны усан флот Япон тэнгист сүйрээд олон жилийн дараа уснаас гаргаж авсан жижиг арьсан богцны доторхыг шинжилбээс борц мах хадгалж байсан нь тогтоогдсон гэдэг юм. Тэгээд ч бидний дээдэс зөвхөн үхэр, тэмээ, ямааны махаа борцолж аян дайндаа авч явдаг байсангүй. Хойлогны мах хүртэл борцолж хатаагаад холын замдаа авч яваад харь дайсны мэсний шарх олсон үедээ идэж, хэдхэн өдөрт тэнхрэн босдог байжээ. Энэ тухай бүр Чингис хаан зарлиг болсон мэдээ баримт ч бий гэнэ лээ. “Махыг жижиг жижиг нарийн зүсэж, нар, салхинд өлгөн хатаах ба тийнхүү давсгүй хатаасан мах нь ямар ч үнэр танаргүй сайхан борц болно” гэж тэртээ 13 дугаар зуунд шашин дэлгэрүүлэх нэрээр явсан, тагнуулч лам Гильом де Рубрук “Дорно этгээдэд зорчсон минь” номдоо тэмдэглэсэн байдаг юм. Ном ч юу байхав дээ, тагнуулын тайлан мэдээндээ шүү дээ. Ийм л эртнээс хийж хэрэглэж, биднийхээ хоол хүнсэнд бүрэн дасан зохицсон махан хүнсээ одоо цагт хор мэтээр өөлөн бичигчдэд өс санадаггүй ч ер би дургүй хүн. Тэгж ярих юм бол бид мэт байтугай биднээс хол явж, нэр олсон зүйл маань борц.

Дунд сургуулийн багш минь нүд нь гялалзаж ирээд л “Монгол хүн сансарт ниссэн явдал бол гайхамшиг. Сансрын нисэгч маань огторгуйн уудамд борцоо аваад явсан юм. Одоо ч сансрын нисэгчид хүнсэндээ борц хэрэглэдэг” гэхэд тэр үед үнэхээр биширмээр санагдаж, нарийн бүдүүн гэдсэндээ борцны цагаан хорхойтой ч түүнийгээ мартан баясан хөөрдөг байлаа. Хожим Ж.Гүррагчаа баатрын нэгэн өгүүллийг уншаад сансарт ниссэн борц махаараа үнэн бахархаж билээ.

Гурван сая биднээс цас мөсний орон өмнөд туйлд тийм ч олон хүн очоогүй. Миний мэдэхээр цаг уурын инженер Ж.Цэрэндэлэг гуай л тэнд очиж ажиллаж, амьдарч байхдаа олон улсын эрдэм шинжилгээний багийнхандаа борцтой шөлөө хийж өгөөд,

өнөөдүүл нь амт шимтийг нь шагшин магтаж гадны тэр олон судлаачид Монголчууд биднийг бишрэн хүндэлсэн гэдэг. Манай нэртэй хүнс судлаач Ж. Октябрь гуайн нийтлэлээс энэ тухай уншаад одооны багачуулын элбэг ярьдгаар үнэхээр “омогшсон” гэж байгаа. Ж.Октябрь гуай тэрхүү нийтлэлдээ “214 гр борц 1 кг ястай махтай тэнцэнэ. Борц нь химийн найрлага, илчлэг чанарын хувьд шинэ махнаас дутахааргүй болохыг манай эрдэмтдийн судалгаа харуулж байна. Тухайлбал, борцолсон махны хуурай үлдэгдлийн 80 орчим хувь нь уураг байдаг учир амьдралд хэрэгцээтэй олон тооны амин хүчлээр элбэг болохыг эрдэмтдийн хийсэн судалгаа нотолжээ” хэмээн шинжлэх ухааны талаас нь шинжлэн бичсэн байв. Бас хар багаасаа ном бүтээлийг нь шимтэн уншдаг байсан эрдэмтэн Г.Гонгоржав гуай “Борц нь 3-5 сарын хугацаанд бэлэн болно. Сайн болсон борц ястай махнаас 4 дахин хөнгөн, чийг нь 7.5%-аас ихгүй, сэвсгэр зөөлөн болсон байна. Тэмээ, үхрийн борцонд чийг 4.8-7.1, уураг 65-89, тослог 12.5 хувь байдаг байна” гэж бичсэнийг уншсанаа тэмдэглэлийн дэвтрийн буланд тэмдэглэсэн байснаа олж харав. Борц маань ямартаа ч шинэ махнаас үл дутах шим тэжээлтэй ажээ. Сансар эзэмшсэн, цөмийн физик, нанотехнологи зэрэгтэй харьцуулж хэлэхгүй л дээ, гэхдээ мах борц боловсруулах арга ухаан бол эртнээс бидний нээсэн шинэ нээлт яах аргагүй мөн. Тэр л цагаас би борцыг хатсан бор мах гэхээсээ илүү даяар монголчуудын хүн төрөлхтөнд бэлэглэсэн хүнсний технологийн нээлт гэж харах болов. Нээлт гэснээс бас амталж шарсан мах байна. Манай дээдэс баатрууд бамбайгаа хөмөрч гал дээр тавиад л махаа шарж иддэг байжээ. Одоогийн барбекью чинь тэр. Үнэндээ шорлог мах чинь Кавказынх биш анхнаасаа биднээс үүдэлтэй юм. Шашлык гэдэг нь шорлог юм шүү дээ. Нууц товчоонд минь хүртэл шорлог гэсэн үг орсон нууц яриа буйг Ш.Гаадамба гуайн номоос олж уншаарай л даа. Ер нь махыг янз янзаар боловсруулж зооглох нь эртнээс “махсаг” бидэнтэй илүү холбоотой байж таарна.

Славянчуудын “борш” хэмээх шөл байна. Түүхэн хэл зүйн талаасаа “борц-борш” хоёр шууд холбоотой гэж би хэлж мэдэхгүй. Бас манай борцтой шөлний нэр тэнд тэгж хувираад явж буйг хэн үгүйсгэж чадах билээ. Лав л орос хэлний толь бичигт борш гэдэг үгийн гарлыг тодорхой хэлсэн зүйл, тодорхой утга байхгүй. Түүхэнд нь ч тэр 13 дугаар зууны үеэс холбогдуулж бичсэн байдаг юм. Украин, Польш хавиар дэлгэрсэн борш шөлийг яаж хийдгийг нь сонирхоод харж байхад яах аргагүй л манай талын тос өөх, холио хутгаа л яваад байх шиг байдаг юм. Эрхэм мэргэн уншигч та бүхэн энэ этгээд ёстой хальж хатуурч байна даа гэж бодож байж болох юм. Тэгвэл судлаач Б.Энх-Өлзий нэгэн өгүүлэлдээ ийнхүү бичжээ. “Тухайлбал буурч гэх тогооч нар гол мөрөн, худаг устай буудаллах газраа товлон давхиж хүрээд хүрээгээр буухад зохицсон олон анги гал түлж түүндээ чулуу улайсган хүлээдэг аж. Буудалласан цэргүүд өөрийн модон аягаа гаргаж ус дүүргээд халуун чулууг хийж буцалган борцоо хийж, ойр хавиасаа шимтэй ургамал ногоогоор /тухайлбал зэрлэг сонгино, хөмөл, таана, халиар г.м/ амталж хоол болгон иддэг байжээ. Энэ нь орчин үеийн БЭЛЭН ХООЛ /Hot dog/-ны эхлэл юм” гэсэн байна. Түүний бичсэнээр “бэлэн хоол” л лав манайх болж байна. Түүнтэй адил борш гэдэг нь борцтой шөлний маань “дүү” хувирал явж байхыг яаж мэдхэв. Гэхдээ энэ бол зүгээр л таамаглал төдий гэдгийг бодоорой.

Сонин юм шүү. Борц нь яах аргагүй “-бор”-“борлох” гэдэг монгол үгийн язгуур атал Борц нэртэй хүн лав өнөөгийн “Монголын хүн ам, өрхийн мэдээллийн санд” бүртгэгдээгүй байгаа юм. Одоохондоо Борц гэдэг нэртэй нэг ч монгол хүн байхгүй л гэсэн үг. Гэтэл Польш, Литви, Украин, Орос улсад Борц нэртэй хүмүүс цөөнгүй байдаг юм билээ. Шууд л манай борцны нэрээр нэрлэсэн гэж гөрдөх гээгүй. Зүгээр л сонирхуулахад тийм байна. Саяхандаа оросын кино урлагийн сайтад Николай Борц гэдэг залуу найруулагчийн олон ангит киноны талаар бичсэн шүүмж хэвлэгдсэн байсан юм даг. Тэгээд цааш нь сонирхоод хайсан чинь Борц гэдэг нэртэй хүүхдийн зохиолч бас байдаг юм билээ. Сонин юм шүү.

Харин намайг залууд ах дүүс, амраг садан “борц шиг бор юм” гэдэг байлаа. Бодвол харваас туранхай хар юм явсан болохоор тэгж дуудах. Одоо ч тарган цагаан юм алга. Тэгээд ч Я.Цэвэл аругайн монгол хэлний тольд энэ үгийг “урь идүүлж

хатаасан мах, - хатингар туранхай” гэсэн үндсэн болон шилжсэн утгаар тайлбарласан байдаг юм.

Хэдэн жилийн өмнө олон улсын зохиолчдын сургалтад гурван сар суухаар харь орныг зорив. Аяны богцондоо хэдэн гозгор борц гялгар уутанд хийгээд ёроолд нь нуув. Хил гаалийн газарт нэг муу тарвага шиг тагдгар шар нохой шинжилсээр байгаад нуусан борцыг минь олж, цүнх савыг минь эзэд нь хайр найргүй зад татаад хураагаад авчхаж билээ. Арай л алаг нүдний нулимс асгараагүй. Хүний газар хүнсээ хураалгах ямар олиг байх вэ дээ? Тэр газар хэдэн сар суухад ууттай хэдэн гозгор борц минь л бодогдсоор байж билээ. Хүний нутаг, гүний хошууд тэгэхлээр бид эх орон, эцэг эхээсээ дутахгүй муу борцоо их санадаг л байж таарах нь. Монгол хүний мөн чанар гэвэл арай л дэндүүлсэн болох тул энэ хүрээд зогсов.

Өглөө эртээ босоод өвлийн эхээр л говийн нар салхинд хатаасан ямааны борцоо хугалаад будаатай цайндаа хийж үйв. Үнэр нь гэр дүүрээд л сэтгэлд өөг сайхан байлаа. Үнэндээ хуршсан мах идээд ходоод гэдэсний хэцүү нэрт өвчин тусаад үхдэг байсан ч борцноосоо л би лав буцахгүй.

ГАРЦААГҮЙ ПҮРЭВХҮҮГИЙН БАТХУЯГ  
2020-04-20

